

# УВС АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД

## БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ БАТБУЯНГИЙН СУМЪЯА-ЫН

### МӨРИЙН ХӨТӨЛБӨР

#### НЭГ : ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ, ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

##### **1.1 Гэр бүл, хувь хүний хөгжил**

- 1.1.1 Хорт хавдар, халдварт өвчин, бэлгийн замын халдварт өвчний эрт үеийн илрүүлэлт, урьдчилан сэргийлэлтэд онцгойлон анхаарч ажиллана.
- 1.1.2 Багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалт, үйл ажиллагаанд анхаарч ажиллана.
- 1.1.3 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих орчныг бүрдүүлж ажиллах тал дээр анхаарна.
- 1.1.4 Инженерийн дэд бүтэц бүхий хувийн сууц барьж буй өрхийг ипотекийн зээлд хамруулах ажлыг дэмжиж ажиллана.
- 1.1.5 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх ажлуудыг хэрэгжүүлнэ.
- 1.1.6 Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж ажиллана.
- 1.1.7 Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход анхаарч ажиллана.
- 1.1.8 Ахмад настны чөлөөт цагаа өнгөрөөх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төвүүдийг сумдад бий болгож ажиллахыг ИТХ-аар батлуулах талаар анхаарч ажиллана.

##### **1.2 ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ**

- 1.2.1 Малчид, тариаланчдын сайхан амьдрах орчныг сайжруулж тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоход анхаарна.
- 1.2.2 Мал эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажил, малын тоог чанарт шилжүүлэх ашиг шим, хүртээмжийг сайжруулах талаар дүрэм журам боловсруулж ажиллана.
- 1.2.3 Монгол Улсын Засгийн Газар бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж зээлээр хөнгөн үйлдвэр, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг зохион байгуулж ажиллана.
- 1.2.4 Суманд үсчин, зурагчин, гутал, зурагт, гар утас засвар, оёдлын гэх мэт ахуйн үйлчилгээний нэгдсэн төвийг байгуулах, ажилчдыг сургах, ажлын байрыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

- 1.2.5 Увс, Хяргас нууруудыг дагасан өвөл, зуны аялал жуулчлалын цогцолбор бий болгон хөгжүүлж ажиллана.

## **ХОЁР: БАЙГАЛЬ ОРЧНЫ ХӨГЖИЛ, СУМЫН ХӨГЖИЛ**

### **2.1 Байгаль орчны хөгжил**

- 2.1.1 Цөлжилтийг бууруулах, хөрс хамгаалах, байгаль орчинг сэргээх, ган зудын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн үүднээс Баруунтуруун, Хартолгой гэх мэт газар тариалангийн бүсийг тариалангийн талбайн газрын тусгай хэрэгцээний газраар авч шийдвэрийг ИТХ гаргуулах
- 2.1.2 Малчдын хүсэлт, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэж бэлчээрийг усжуулах, худаг ус гаргах ажлыг зохион байгуулах.
- 2.1.3 Иргэдийн уул уурхайд тавих хяналт, оролцоог сайжруулж, хууль зөрчиж олгогдсон тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах саналыг холбогдох төрийн байгууллагад хүргүүлнэ.

### **2.2 Сумын хөгжил**

- 2.2.1 Ногоон байгууламжуудыг нэмэгдүүлэн хүүхдийн чөлөөт цагаа өнгөрөөх аюулгүй орчныг бүрдүүлж ажиллана.
- 2.2.2 Суманд гэр хорооллын дэд бүтцийн ажлыг эхлүүлж, хашаандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.2.3 Шинээр атаршсан, хөрсний эвдрэлд орсон газруудыг дахин төлөвлөх замаар эдийн засгийн эргэлтэд оруулна.